



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.20 № 134

танай _____-ны № _____-Т

ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
С.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд 2023 оны санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 50.5 сая төгрөгийн Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулиудыг хэрэгжүүлээгүй байсан зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, цаашдын үйл ажиллагаандаа хуулийг мөрдөж ажиллах, албан шаардлага тогтоосныг хүргүүлээ.

Албан шаардлагыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A5 toot

015030410



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 214/А156034910В.А - 2024/78/НА - СТА - ТШЗ
Арвайхээр сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн танай байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас Биеийн тамирын арга зүйч / орон тоо батлагдаагүй/ албан тушаалтанд 3983.7 мянган төгрөгийн цалин олгосон. Мөн гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, тайлан огт байхгүй, ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Есөнзүйл сумын ЗДТГ-ын дарга /С.Бат-Эрдэнэ/, нягтлан бодогч /Ж.Байгалмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

О. БАТЖАРГАЛ
Б. ЭРДЭНЭЦЭЦЭГ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 215/А1560349/ОБА-2024/78/НА-СТА-ТЦБ Арвайхээр сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн танай байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас гүүрний засварт 12,000.0 мянган төгрөг, нохой устгалын зардалд 3,643.7 мянган төгрөг, хогийн цэг дарах, янзлах зардалд 19,900.0 мянган төгрөг, нийт 35,543.8 мянган төгрөгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно", МУЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.7-д "Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Есөнзүйл сумын ЗДТГ-ын дарга /С.Бат-Эрдэнэ/, нягтлан бодогч /Ж.Байгалмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
О. БАТЖАРГАЛ
Б. ЭРДЭНЭЦЭЦЭГ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 216/А1560349/ОБА-2024/78/НА-СТА-ТЦЗ
Арвайхээр сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн танай байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1.Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас уртын дууны дугуйлангийн багш /Тус сумын Соёлын төвийн эрхлэгч/-тай гэрээ байгуулж, жилийн 5000.0 мянган төгрөгөөр тохиролцож, 2022 оны урамшууллын дутуу 2500.0 мянган төгрөг, 2023 оны урамшууллыг гэрээгээ дүгнээгүй байхад 5000.0 мянган төгрөгийг олгосон нь ЗД-ын нөөц хөрөнгийн зарцуулалтын журамд хамаарахгүй үйл ажиллагааг санхүүжүүлсэн.

2.Мөн 720.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авч нэр бүхийн 3 иргэнд хүндэтгэл үзүүлсэн.

3.Засаг даргын нөөц хөрөнгийн зардлын төлөвлөлт бусад сумуудтай харьцуулахад өндөр дүнтэй батлагдсан /80.0 сая/. Төсвийн гүйцэтгэлээр 79.648.4 мянган төгрөг зарцуулсны 71 хувийг шагнал урамшуулал, тэтгэмж, тусламж, дэмжлэг болон урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан, 29 хувийг л журмын 2.1.1, 2.1.2-т заасан арга хэмжээнд зарцуулсан нь төсвийн хөрөнгийг төлөвлөгдөөгүй, үр ашиггүй зүйлд зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Мөн Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын" холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Есөнзүйл сумын ЗДТГ-ын дарга /С.Бат-Эрдэнэ/, нягтлан бодогч /Ж.Байгалмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 217/А/1560349/ӨВА-2024/78/НА-СТА-ТшЗ.
Арвайхээр сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн танай байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэсний нэмэгдлийг 2 албан хаагчид олгохдоо 2,765.7 мянган төгрөгөөр илүү тооцон олгосон.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно", Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 2.2-т "Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээрх зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Есөнзүйл сумын ЗДТГ-ын дарга /С.Бат-Эрдэнэ/, нягтлан бодогч /Ж.Байгалмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **О.БАТЖАРГАЛ**
АХЛАХ АУДИТОР **Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ**